Өмнөговь аймгийн хүн амын сэтгэцийн эрүүл мэндийн зарим асуудал

Л.Өсөхжаргал[1], Т.Ганцэцэг[2]

[1]Өмнөговь аймаг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв
[2]АШУҮИС, АУС, Сэтгэцийн эрүүл мэндийн тэнхим
Цахим шуудан: I8usuhjargal@gmail.com , Утас: 99104782

Түлхүүр үг:

Сэтгэл гутрал
Стресс
Ядралт
Сэтгэл түгшилт
Хөдөө орон нутаг

Товч утга:

Үндэслэл: Цар тахал болон түүнийг дагалдаж гарсан арга хэмжээ нь хүмүүсийн өдөр тутмын амьдралын хэв маягийг өөрчлөх, нийгмийн харилцаа холбоог хязгаарлах, түүнчлэн хамтдаа түгжигдсэн гэр бүлүүдийн хоорондын харилцаа хурцадмал байдалд шилжих, өвчин тусах эсвэл вирус тархахаас эмээх зэрэгт хүргэсэн нь COVID-19 тахал сэтгэцийн эрүүл мэндэд ямар нөлөө үзүүлж байгааг судлах асуудал судлаачдын анхаарлыг татлаа. Мөн цар тахлын дэгдэлт иргэдийн сэтгэлзүйд сөргөөр нөлөөлөн зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэг тухайлбал: сэтгэл түгшилт, сэтгэл гутрал, тайлбарлаж боломгүй биеийн зовиур шаналгаа, нойргүйдэл, архины хэрэглээ зэрэг нэмэгдсэн байна. **Зорилго:** Коронавируст халдварын улмаас үүссэн өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн иргэдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг судлах. **Арга, аргачлал:** 2021 оны 11 сарын 15-ны өдрөөс 12 сарын 20-ны өдрүүдэд нэг агшингийн загвараар, асуумж судалгааны арга ашиглан, limesurvey программ дээр хийж гүйцэтгэсэн. Судалгаанд Өмнөговь аймгийн 14 сумын нийт хүн амаас санамсаргүй түүврийн аргаар 267 иргэн болон 81 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг түүвэрлэн авч хамруулсан. Сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг SRQ-20 (Self-reporting questionnaire), Patient Health Questionnaire (PHQ-9) стандарт асуумжуудаар тус тус үнэлсэн. Статистик боловсруултыг SPSS 24 программыг ашиглаж хийсэн. Судалгааны ёс зүйн зөвшөөрлийг ЭМЯ-ны АУ-ны ёс зүйн хяналтын хорооны 2021 оны 11 сарын 9-ний өдрийн хурлаар авсан (№267 тоот). **Үр дүн:** Судалгаанд 18-70 насны Ковид-19-ийн халдварын үед үүрэг гүйцэтгэж буй эмч, сувилагч, цагдаа, онцгой байдлын 111 ажилчид болон 165 иргэн, нийт 267 хүн хамрагдсаны 94 эрэгтэй, 173 эмэгтэй байлаа. Үүнээс эмч, эмнэлгийн ажилтан 81 хамрагдсан байна. судалгаанд хамрагдагсдын 56.2% нь архаг сульдлын хамшинжтэй, 53.6% нь сэтгэл түгших хамшинжтэй, 47.9% нь биеших эмгэгтэй, 36.7% нь сэтгэл гутрах хамшинжтэй байлаа. Судалгаанд хамрагдсан иргэдийн 59.3% нь архаг ядаргаа, 58.7% нь сэтгэл түгшилт, 56.3% нь биеших эмгэг, 58.2% нь сэтгэл гутрах эмгэгтэй, ковид-19 халдварын үед үүрэг гүйцэтгэж байгаа ажилтан, алба хаагчдын 40.7% нь архаг ядаргаа, 41.3% нь сэтгэл түгшилт, 41.8 нь биеших эмгэг, 41.8% нь сэтгэл гутрах эмгэгтэй, эмч эмнэлгийн ажилчдын 34.7% нь архаг ядаргаа, 33.6% нь сэтгэл түгшилт, 35.9% нь биеших, 38.8% нь сэтгэл гутрах зэрэг эмгэгтэй байлаа. **Дүгнэлт:** Эмч, эмнэлгийн ажилчид болон Ковид-19 халдварын үед үүрэг гүйцэтгэж байгаа ажилтан, алба хаагчид нь иргэдтэй харьцуулахад архаг ядаргаа, сэтгэл түгшилт болон биеших эмгэгээр илүү өвчилсөн байна.

Үндэслэл: КОВИД-19 нь 2019 оны 12 сард БНХАУ-ын Хубэй мужийн Ухань хотын далайн бүтээгдэхүүний хүнсний захаар үйлчлүүлсэн хүн амын дунд анх бүртгэгдсэн ба 2020 оны 3-р сарын 11-нд КОВИД-19-ийг цар тахал хэмээн ДЭМБ-аас зарласан. Бид 2020 онд COVID-19 цар тахлыг 2021 онд дуусч, хүн төрөлхтөний хэвийн амьдрал сэргэнэ гэж найдан хүлээж байсан. Гэвч нөхцөл байдал бидний хүссэнээр эргээгүй бөгөөд уг халдвар өнөөдрийг хүртэл үргэлжилсээр 2022 оны есдүгээр сарын 5-ны байдлаар COVID-19-ийн халдвар батлагдсан 600.366.479 тохиолдол бүртгэгдсэний 6.460.493 нь нас барсан гэж ДЭМБ-аас мэдээлжээ.[1] Цар тахал болон түүнийг дагалдаж хэрэгжүүлж буй арга хэмжээ нь хүмүүсийн өдөр тутмын амьдралын

хэв маягийг өөрчлөх, нийгмийн харилцаа холбоог хязгаарлах, түүнчлэн хамтдаа түгжигдсэн гэр бүлүүдийн хоорондын харилцаа хурцадмал байдалд шилжих, өвчин тусах эсвэл вирус тархахаас эмээх зэрэгт хүргэсэн нь COVID-19 тахал сэтгэцийн эрүүл мэндэд ямар нөлөө үзүүлж байгааг судлах асуудал судлаачдын анхаарлыг татсан.[3] Хэвлэлийн тоймуудаас үзвэл 2020 оны 4-р сараас 6-р сар хүртэл хугацаанд 78 орны 9565 хүний дунд хийсэн судалгаагаар хөл хорио цээрийн дэглэмийн оргил үед хүмүүсийн ихэнх нь дунд зэргийн стресстэй, 11% нь их стресстэй байсан ба сэтгэл гутралыг илтгэх шинж тэмдгүүд өндөр илэрсэн байна. Тухайлбал оролцогчдын 50 орчим хувь нь маш их цаг үрэгдэж байна гэсэн бол 33% нь уйтгартай байна гэж хариулжээ.[4] Мөн 2020 оны 4-р сард АНУ-д хийсэн судалгаагаар насанд хүрэгчдийн 13.6%-д дистрессийн шинж тэмдэг ноцтой түвшинд илэрсэн нь 2018 оны судалгаатай харьцуулахад 3 дахин ихэссэн байна.[5] Тус улсад 2020 оны 3-4 дүгээр саруудад хийгдсэн судалгаанд насанд хүрэгчдийн сэтгэл гутралын тархалт тахлын өмнөх үеийнхтэй харьцуулахад 3 дахин их байжээ.[6]

Их Британид 2020 оны 4 дүгээр сард буюу хөл хорио үргэлжилсэн нэг сарын хугацаанд хүн амын дунд дистрессийн тархалтыг судлахад 2018-2019 оноос 8%-аар өсөж 27% болсон байна.[7] Харин БНХАУ-д 2020 оны 2-3 дугаар саруудад хийгдсэн судалгаанд Хубэй мужийн Ковидын тусламж үзүүлэх тусламжийн тэргүүн эгнээнд ажилласан эмнэлгийн ажилчдын 30.43% сэтгэл гутралтай, 20.29% нь сэтгэл түгшилттэй, 14.49% нь нойргүйдэлтэй байсан бол хятадын бусад бүс нутгийн эмнэлгийн ажилчдын 23.13% нь сэтгэл гутралтай, 13.14% нь сэтгэл түгшилтэй, 10.64%-д нь нойргүйдэл илэрсэн байна. Харин Хубэй мужийн нийт хүн амын 23.33%-д сэтгэл гутрал, 16.67%-д сэтгэл түгшилт, 6.67%-д нойргүйдэл илэрсэн бол бусад бүс нутгийн нийт хүн амын 18.25%-д нь сэтгэл гутрал, 9.22%-д нь сэтгэл түгшилт, 7.17%-д нойргүйдлийн шинж тэмдэг илэрчээ.[8]

Мөн түүнчлэн Deng J нарын 2020 онд COVID-19-өөр өвдсөн өвчтөнд сэтгэлийн хямрал, түгшүүр, нойрны хямралын тархалтыг үнэлсэн нийт 31 судалгааны ажилд мета-анализ хийж судалсан судалгаанд сэтгэл гутрал 45%, сэтгэл түгшилт 47%, нойрны хямрал 34%-ийн тархалттай байгааг тогтоожээ.[9] Харин манай орны судлаач Р.Энхтүвшин нарын 2021 оны 5-7 сард Ковид-19 халдварын улмаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн дунд сэтгэцийн эрүүл мэндийг судалсан судалгаанд 47.7% нь сэтгэл гутралтай, 44% нь сэтгэл түгшилттэй, 47% нь нойрны хямралтай байжээ.[10] Иймд бидний өмнө Монгол улсын говийн бүсийн аймгуудын хүн амын дунд ковидын үеийн сэтгэцийн тулгамдсан асуудлыг үнэлэх хэрэгцээ шаардлага тулгарсан нь уг судалгааг хийх үндэслэл болсон.

Зорилго: Коронавируст халдварын улмаас үүссэн өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн иргэдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг судлах.

Зорилт:


1. Коронавируст халдварын улмаас үүссэн өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн иргэдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг үнэлэх.
2. Коронавируст халдварын бүсд үүрэг гүйцэтгэж байгаа ажилтан, алба хаагчид болон эмч, эмнэлгийн ажилчдын сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг үнэлэх.
3. Иргэдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг Коронавируст халдварын бүсд үүрэг гүйцэтгэж байгаа ажилтан, алба хаагчид болон эмч, эмнэлгийн ажилчдын сэтгэцийн эрүүл мэндийн байдалтай харьцуулж судлах.

Арга, аргачлал: 2021 оны 11 сарын 15-ны өдрөөс 12 сарын 20-ны өдрүүдэд 5 долоо хоногийн хугацаанд нэг агшингийн загвараар судалгааг хийж гүйцэтгэсэн. Судалгаанд Өмнөговь аймгийн 14 сумын нийт хүн амаас санамсаргүй түүврийн аргаар 267 иргэн болон 81 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг түүвэрлэн авч хамруулсан. Сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлохдоо асуумж судалгааны арга ашиглаж limesurvey программ дээр асуумжийг бөглүүлсэн. Сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг ДЭМБ-аас 1994 онд зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийг илрүүлэх 20 асуулт бүхий илрүүлгийн SRQ-20 (Self-reporting questionnaire), эрүүл мэндийн анхан шатны тусламжинд хандаж буй үйлчлүүлэгчийн сэтгэл гутралын илрэлийн түвшинг үнэлэх сэтгэл гутралын илрүүлгийн 9 асуулт бүхий Patient Health Questionnaire (PHQ-9) стандарт асуумжуудаар тус тус үнэлсэн. SRQ-20 (Self-reporting questionnaire)-ийн мэдрэг чанар 83%, өвөрмөц чанар 80% байдаг бол Patient Health Questionnaire (PHQ-9) асуумжийн мэдрэг чанар 0.88 байдаг. Статистик боловсруултыг SPSS 24 программыг ашиглаж хийв. Судалгааны ёс зүйн зөвшөөрлийг ЭМЯ-ны АУ-ны ёс зүйн хяналтын хорооны 2021 оны 11 сарын 9-ний өдрийн хурлаар авсан (№267 тоот).

Үр дүн: Судалгаанд 18-70 насны Ковид-19-ийн халдварын үед үүрэг гүйцэтгэж буй эмч, сувилагч, цагдаа, онцгой байдлын 111 ажилчид болон 165 иргэн нийт 267 хүн хамрагдсаны 94 эрэгтэй, 173 эмэгтэй байлаа. Үүнээс эмч, эмнэлгийн ажилтан 81 хамрагдсан байна (Хүснэгт 1).


Хүснэгт 1. Хүн ам зүйн ерөнхий үзүүлэлтүүдийг иргэд болон Ковид-19 халдварын тусламж үйлчилгээнд дайчлагдан ажилласан алба хаагчидын зарим үзүүлэлттэй харьцуулсан нь

Үзүүлэлтүүд	Нийт n=267	Иргэд	Ковид халдварын үед үүрэг гүйцэтгэж байгаа ажилтан, алба хаагчид		Эмч, эмнэлгийн ажилтан		
					тийм	үгүй	P утга
	n (%)	156 (58.4)	105 (41.6)	P утга	186 (69.7)	81 (30.3)	
Хүйс							
Эмэгтэй	173 (64.8)	96 (55.5)	77 (44.5)	0.187	66 (38.2)	107 (61.8)	0.000
Эрэгтэй	94 (35.2)	60 (63.8)	34 (36.2)		15 (16.0)	79 (84.0)	
Насны бүлэг							
18-19	10 (3.7)	10 (100.0)	0 (0.0%)	0.010	0 (0.0)	10 (100.0)	0.112
20-29	85 (31.8)	52 (61.2)	33 (38.8)		27 (31.8)	58 (68.2)	
30-39	73 (27.3)	33 (45.2)	40 (54.8)		29 (39.7)	44 (60.3)	
40-49	44 (16.5)	28 (63.6)	16 (36.4)		12 (27.3)	32 (72.7)	
50-59	45 (16.9)	25 (55.6)	20 (44.4)		11 (24.4)	34 (75.6)	
60-70	10 (3.7)	8 (80.0)	2 (20.0)		2 (20.0)	8 (80.0)	
Боловсрол							
Боловсролгүй, бага	8 (3.0)	8 (100.0)	0 (0.0)	0.000	0 (0.0)	8 (100.0)	0.000
Бүрэн бус дунд	32 (12.0)	27 (84.4)	5 (15.6)		3 (9.4)	29 (90.6)	
Бүрэн дунд	57 (21.3)	46 (80.7)	11 (19.3)		7 (12.3)	50 (87.7)	
Тусгай мэргэжил	29 (10.9)	16 (55.2)	13 (44.8)		10 (34.5)	19 (65.5)	
Дээд	128 (47.9)	53 (41.4)	75 (58.6)		55 (43.0)	73 (57.0)	
Эрдмийн зэрэг цолтой	13 (4.9)	6 (46.2)	7 (53.8)		6 (46.2)	7 (53.8)	
Ажил							
Оюутан, сурагч	10 (3.7)	10 (100.0)	0 (0.0%)	0.000	0 (0.0)	10 (100.0)	0.000
Улсын байгууллага	189 (70.8)	78 (41.3)	111 (58.7)		81 (42.9)	108 (57.1)	
Хувиараа (хувийн байгууллага)	26 (9.7)	26 (100.0)	0 (0.0)		0 (0.0)	26 (100.0)	
Тэтгэвэр	6 (2.2)	6 (100.0)	0 (0.0)		0 (0.0)	6 (100.0)	
Ажилгүй	14 (5.2)	14 (100.0)	0 (0.0)		0 (0.0)	14 (100.0)	
Хөдөлмөрийн чадвар алдсан	2 (0.7)	2 (100.0)	0 (0.0)		0 (0.0)	2 (100.0)	
Бусад	20 (7.5)	20 (100.0)	0 (0.0)		0 (0.0)	20 (100.0)	
Гэр бүл							
Бусад	4 (1.5)	2 (50.0)	2 (50.0)	0.839	2 (50.0)	2 (50.0)	0.931
Бэлэвсэн	8 (3.0)	5 (62.5)	3 (37.5)		2 (25.0)	6 (57.0)	
Гэрлэсэн	186 (69.7)	104 (55.9)	82 (44.1)		56 (30.1)	130 (69.9)	
Огт гэрлээгүй	39 (14.6)	26 (66.7)	13 (33.3)		11 (28.2)	28 (71.8)	
Салсан	13 (4.9)	8 (61.5)	5 (38.5)		5 (38.5)	8 (61.5)	
Хамтран амьдрагчтай	17 (6.4)	11 (64.7)	6 (35.3)		5 (29.4)	12 (70.6)	



Зураг 1. Судалгаанд хамрагдагсдын сэтгэцийн эмгэгийн эзлэх хувийг SRQ 20 асуумжаар үнэлсэн дүн

Зураг 1-ээс харахад судалгаанд хамрагдагсдын 56.2% нь архаг сульдлын хамшинжтэй, 53.6% нь сэтгэл түгших хамшинжтэй, 47.9% нь биеших эмгэгтэй, 36.7% нь сэтгэл гутрах хамшинжтэй байлаа.



Зураг 2. Сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг иргэн, ковид халдварын үед үүрэг гүйцэтгэж байгаа ажилтан, алба хаагчид болон эмч, эмнэлгийн ажилтан бүлэгтэй харьцуулан судалсан дүн

Зураг 2-оос харахад судалгаанд хамрагдсан иргэдийн 57.1% нь архаг ядаргаа, 53.8% нь сэтгэл түгшилт, 46.2% нь биеших эмгэг, 29.5% нь хөнгөн сэтгэл гутрах эмгэгтэй байхад Ковид-19 халдварын үед үүрэг гүйцэтгэж байгаа ажилтан, алба хаагчдын 55.0% нь архаг ядаргаа, 53.2% нь сэтгэл түгшилт, 50.5% нь биеших эмгэг, 27.9% нь хөнгөн сэтгэл гутрах эмгэгтэй, эмч эмнэлгийн ажилчдын 64.2 % нь архаг ядаргаа, 59.3% нь сэтгэл түгшилт, 56.8% нь биеших, 30.9% нь хөнгөн сэтгэл гутрах эмгэгтэй байна. Эмч, эмнэлгийн ажилчид болон Ковид-19 халдварын үед үүрэг гүйцэтгэж байгаа ажилтан, алба хаагчид нь иргэдтэй харьцуулахад архаг ядаргаа, сэтгэл түгшилт болон биеших эмгэгээр илүү өвдөж байгаа нь харагдаж байна. Мөн судалгаанд хамрагдсан иргэдийн 56.4%, Ковид-19 халдварын үед үүрэг гүйцэтгэж байгаа ажилтан, алба хаагчдын 43.9%, эмч эмнэлгийн ажилчдын 31.5% нь Ковидын дархлаажуулалтанд хамрагдсан байсан бол Ковидын халдвараар иргэдийн 53.4%, ковид-19 халдварын үед үүрэг гүйцэтгэж байгаа ажилтан, алба хаагчдын 38.4%, эмч эмнэлгийн ажилчдын 25.6% нь өвдсөн байв.

Хэлцэмж: Коронавируст цар тахал хүн бүрийн амьдралд нийгэм, эдийн засгийн шууд болон шууд бус нөлөөлөл үзүүлж байна. Сэтгэцийн эрүүл мэндийн талаас үүсэж буй тулгамсан асуудлууд нь дэлхий нийтийн анхаарлыг татаж тасралтгүй судлагдсаар байна. 2020 онд судлаач Nochaiwong S нар 32 улсын цахим мэдээллийн санд тулгуурлан, 398771 хүний материалд судалгаа хийсэн. Энэ судалгаанд COVID-19 халдварын тархалтын үед сэтгэл түгших эмгэг 26.9%, сэтгэл гутрах эмгэг 28.0%-тай байсан бол Deng J нарын олон улсын 31 судалгаанд дүн шинжилгээ, мета-анализ хийсэн судалгаанд сэтгэлийн түгшүүр (47%), сэтгэл гутрал (45%), нойрны эмгэг (34%) байв[9,11].

Харин бидний судалгаанд хамрагдагсдын 53.6% сэтгэл түгшилт, 36.7% сэтгэл гутралтай байгаа нь Nochaiwong S нарын судалгааны дүнгээс харьцангуй өндөр байсан бол судлаач Deng J нарын хийсэн мета-анализ судалгааны дүнтэй харьцуулахад сэтгэл түгшилт нь бага зэрэг өндөр сэтгэл гутрал нь бага зэрэг бага хувьтай гарсан байна. Энэ нь бид судалгаандаа мэдрэг байдал өндөртэй сэтгэцийн зонхилон тохиолдох эмгэгүүдийг илрүүлдэг SRQ илрүүлгийн асуумжийг хэрэглэж мэдээ мэдээллээ цуглуулсантай холбоотой байж болох юм.

Манай улсын судлаач Р.Энхтүвшин нар 2021 оны 5-7 сард Ковид-19 халдварын улмаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг судласан. Энэ судалгаанд хамрагдсан эмчлүүлэгчдийн 47.7% сэтгэл гутралтай, 44% сэтгэл түгшилттэй, 47% нойрны хямралтай байсан байна[10]. Уг судалгааны дүнг бидний судалгааны дүнтэй харьцуулахад сэтгэл гутралын эзлэх хувь харьцангуй өндөр байгаа нь судлаачид уг судалгааг эмнэлэгт суурилж хийснээс гадна сэтгэл гутрал, сэтгэл түгших эмгэгийг илрүүлэх өөр стандарт асуумж хэрэглэсэн нь нөлөөлсөн байж болох юм. Эрүүл мэндийн ажилтнууд Ковид-19 тахлын халдвараар өвдөх эрсдэл нэмэгдэх, бусдад халдвар тараахаас эмээх, гэр бүлээсээ тусгаарлагдах, илүү цагаар ажиллах, урт хугацаанд ээлжээр ажиллах зэрэг онцгой нөхцөлд ажиллахаас гадна өвчтөний зовлон шаналал, үхлийг шууд харах зэрэг хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалж бусад олон мэргэжлийн бүлгүүдээс илүү стресст өртөж сэтгэцийн тулгамдсан асуудал үүсэх эрсдэл өндөр байна.

Хэвлэлийн тоймоос үзвэл судлаачид эрүүл мэндийн ажилтнуудын ковидтой холбоотой стресс, сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг маш их судалсан байна. Тухайлбал: Судлаач Al Maqbali нар 2020 оны 1-р сараас 9-р сарын хооронд нийтлэгдсэн 93 судалгаанд мета-анализ шинжилгээ хийж үзэхэд стрессийн нийт тархалт 40 судалгаанд үндэслэж 43%, сэтгэл түгшилтийн тархалт 73 судалгаанд үндэслэж 37%, сэтгэл гутралын тархалт 62 судалгаанд үндэслэж 35%, нойрны хямрал 18 судалгаанд үндэслэж 43%-тай байна гэжээ. Үүнээс гадна уг судалгаагаар Ковид-19 тахлын үед ажиллаж байсан сувилагчдын

гуравны нэг-д сэтгэцийн эмгэг шинж тэмдэг илэрсэн нь тогтоогджээ.[12] Энэ үр дүн нь SARS гэх мэт жижиг цар тахлын үед ажиллаж байсан сувилагчдад хийсэн судалгааны үр дүнгээс эсвэл тухайн үеийн нийт хүн амтай харьцуулахад харьцангуй өндөр байна гэжээ.[13]

Испанийн эрүүл мэндийн ажилтнуудын дунд 2020 оны 4 дүгээр сард хийгдсэн судалгааны дүнгээс харахад оролцогчдын талаас илүү хувь нь гэмтлийн дараах стрессийн эмгэг (PTSD) болон сэтгэл түгшилттэй, 50 орчим хувь нь сэтгэл гутралтай байсан ба эмэгтэйчүүд, залуучууд илүүтэй өртөж байжээ.[14] Мөн 2020 оны 2-3 дугаар сард Хятад улсын эмнэлгийн ажилтнуудын дунд хийгдсэн судалгаанд сэтгэл гутрал, сэтгэл түгшилт, нойргүйдэл нэмэгдсэн байна гэж дүгнэжээ.[8] Бидний судалгаанд эмч, эмнэлгийн ажилчидыг ковид-19 халдварын үед үүрэг гүйцэтгэж байгаа ажилтан, алба хаагчид, иргэдтэй харьцуулахад архаг ядаргаа, сэтгэл түгшилт болон биеших эмгэг илүү байгаа нь дээрх судалгаануудын үр дүнг баталж байна.

Дүгнэлт:

1. Коронавируст халдварын улмаас үүссэн өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн иргэдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг үнэлэхэд архаг ядаргаа, сэтгэл түгшилт, биеших эмгэг, хөнгөн сэтгэл гутрах эмгэгтэй байх магадлалтай өндөр байна.
2. Коронавируст халдварын бүсэд үүрэг гүйцэтгэж байгаа ажилтан, алба хаагчид болон эмч, эмнэлгийн ажилчдын сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг судлахад архаг ядаргаа, сэтгэл түгшилт, биеших эмгэг, хөнгөн сэтгэл гутрах эмгэгтэй байх боломжтой байна.
3. Өмнөговь аймгийн иргэдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг үүрэг гүйцэтгэж буй ажилтан, алба хаагчид, эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй харьцуулж судлахад алба хаагчид болон ЭМС-ийн ажилчид сэтгэцийн эмгэгт илүү өртөж байна.

Ном зүй:

1. *Manchia M, Gathier AW, Yapici-Eser H, et al. The impact of the prolonged COVID-19 pandemic on stress resilience and mental health: A critical review across waves. Eur Neuropsychopharmacol. 2022;55:22-83.*
2. *3. Vinkers CH, van Amelsvoort T, Bisson JI, et al. Stress resilience during the coronavirus pandemic. Eur Neuropsychopharmacol. 2020;35:12-16.*
4. *Gloster AT, Lamnisos D, Lubenko J, et al. Impact of COVID-19 pandemic on mental health: An international study. PLoS One. 2020;15(12):e0244809.*
5. *McGinty EE, Presskreischer R, Han H, Barry CL. Psychological Distress and Loneliness Reported by US Adults in 2018 and April 2020. JAMA. 2020;324(1):93-94.*
6. *Ettman CK, Abdalla SM, Cohen GH, Sampson L, Vivier PM, Galea S. Prevalence of Depression Symptoms in US Adults Before and During the COVID-19 Pandemic. JAMA Netw Open. 2020;3(9):e2019686.*
7. *Pierce M, McManus S, Hope H, et al. Mental health responses to the COVID-19 pandemic: a latent class trajectory analysis using longitudinal UK data. Lancet Psychiatry. 2021;8(7):610-619.*
8. *Liang Y, Wu K, Zhou Y, Huang X, Zhou Y, Liu Z. Mental Health in Frontline Medical Workers during the 2019 Novel Coronavirus Disease Epidemic in China: A Comparison with the General Population. Int J Environ Res Public Health. 2020;17(18).*
9. *Deng J, Zhou F, Hou W, et al. The prevalence of depression, anxiety, and sleep disturbances in COVID-19 patients: a meta-analysis. Ann N Y Acad Sci. 2021;1486(1):90-111.*
10. *Р.Энхтүвшин, З.Хишигсүрэн. Ковид-19 өвчний улмаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тал хувь нь сэтгэцийн эмгэгт өртөж байна". "Эрүүл мэндийн салбар 100 жил Эмнэлзүйн анагаах ухааны хөгжил, ирээдүйн чиг хандлага" илтгэлийн хураангуй. УБ хот. 2021 он. х93.*
11. *Nochaiwong S, Ruengorn C, Thavorn K, et al. Global prevalence of mental health issues among the general population during the coronavirus disease-2019 pandemic: a systematic review and meta-analysis. Sci Rep. 2021;11(1):10173.*
12. *Al Maqbali M, Al Sinani M, Al-Lenjawi B. Prevalence of stress, depression, anxiety and sleep disturbance among nurses during the COVID-19 pandemic: A systematic review and meta-analysis. J Psychosom Res. 2021;141:110343.*
13. *Chen CS, Wu HY, Yang P, Yen CF. Psychological distress of nurses in Taiwan who worked during the outbreak of SARS. Psychiatr Serv. 2005;56(1):76-79.*
14. *Lourdes-Moreno. Beatriz Talavera-Velasco, Yolanda García-Albuerne and Jesús Martín-García. Symptoms of Posttraumatic Stress, Anxiety,Depression, Levels of Resilience and Burnout in Spanish Health Personnel during the COVID-19 Pandemic. Int. J. Environ. Res. Public Health 2020, 17, 5514.*

Some problems of mental health among the population of Umnugovi province

Usukhjargal L[1], Gantsetseg T[2]

[1]Unit of Psychiatry and Narcology, Umnugovi province RDTC
[2] Department of Mental Health, School of Medicine, MNUMS
E-mail address: i8usuhjargal@gmail.com, Tel: +976- 99104782

Background: The pandemic and its accompanying measures have led to changes in people's daily lives, limited social contact, strained relationships between locked-in families, fear of contracting or spreading the virus, and the COVID-19 pandemic affecting mental health. The problem of studying the effect is attracting the attention of researchers. There is also an increase in the prevalence of mental disorders such as anxiety, depression, somatization, insomnia, and alcohol consumption, which negatively impact the psyche of citizens associated with the outbreak.
Aim: To study the mental health status during heightened preparedness for the coronavirus pandemic.
Materials and Methods: From November 15 to December 20, 2021, it was carried out according to the lime survey program using a one-time model and the questionnaire survey method. For the study, 267 citizens, 81 doctors, and medical specialists were randomly selected from the total number of residents of 14 soums of the Umnugovi province. Mental health status was assessed using the standard SRQ-20 (Self-Report Questionnaire) and the Patient Health Questionnaire (PHQ-9). Statistical analysis was performed using SPSS 24 software. Ethical approval was obtained at the meeting of the Ethics Control Committee of the Ministry of Health on November 9, 2021 (No. 267)
Results: The study involved 111 doctors, nurses, and of the workers and employees that work for COVID-19 infection, and 165 citizens in a total of 267 people with 94 men and 173 women aged 18 to 70 years. Of these, 81 doctors and medical staff were involved. 56.2% of respondents had chronic fatigue syndrome, 53.6% had anxiety syndrome, 47.9% had somatization syndrome, and 36.7% had the depressive syndrome.
Among the citizens surveyed, 59.3% had chronic fatigue, 58.7% had anxiety, 56.3% had obsessive-compulsive disorder, and 58.2% had depressive disorder, then during the spread of COVID-19, 41.3% of employees had anxiety disorder and 41.8% obsessive-compulsive disorder then hospital workers and doctors had a depressive disorder in 34.7%, chronic fatigue in 33.6%, anxiety disorder in 35.9% and depression in 38.8%.
Conclusion:

1. When assessing the mental health of the community during the coronavirus pandemic lockdown, chronic fatigue, anxiety, obsessive-compulsive disorder, and mild depression are more common.
2. When studying the mental health situation of employees, officers, physicians, and health care workers who are working during the coronavirus pandemic isolation, chronic fatigue, anxiety, obsessive-compulsive disorder, and mild depression are more common.
3. When comparing the mental health situation of the local community to those of employees, physicians, and health care workers who are working on duty, the employees and health care specialists are more affected by mental disorders.

Keywords: Depression, stress, fatigue, anxiety, countryside.